



## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2021 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 38

Улаанбаатар хот

Ардчилсан намын бүртгэлийн мэдээлэлд  
өөрчлөлт оруулах хүсэлтийн тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Ч.Тунгалаг, Г.Алтанчимэг, Ч.Хосбаяр, шүүгч С.Батдэлгэр, Б.Батцэрэн, Х.Батсүрэн, Г.Банзрагч, П.Золзаяа, Б.Мөнхтуяа, Д.Мөнхтуяа, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Д.Цолмон, Б.Цогт, Ц.Цогт, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар, Ардчилсан намын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Ган-Очирос ирүүлсэн “Ардчилсан намын даргаар Одонгийн Цогтгэрэлийг бүртгүүлэх” хүсэлтийг шүүгч Д.Мөнхтуяагийн илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Ардчилсан намын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Ган-Очирос 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 02/204 дүгээр албан бичгээр Улсын дээд шүүхэд хандаж ирүүлсэн хүсэлтдээ:

“Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 3 дахь заалтад “Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, ... нийтэд ил тод байна” гэж, Улс төрийн намын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Намын дотоод зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог намын дүрмээр зохицуулна” гэж тус тус заасны дагуу Ардчилсан нам Улсын дээд шүүхэд бүртгэлтэй Үндсэн дүрмийнхээ хүрээнд Ээлжит бус Эвлэрлийн Их хурлаа 21 аймаг, 330 сум, 9 дүүрэг, 170 хороодоос сонгогдож, томилогдсон нийт 1318 төлөөлөгчөө оролцуулан Их Эзэн Богд Чингис хааны мэндэлсэн билгийн тооллын өвлийн тэргүүн сарын шинийн нэгэн буюу 2021 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр Улаанбаатар паласын концертын Их танхимд “Онц Их Хурал” нэрийн дор амжилттай зохион байгууллаа.

Улсын дээд шүүхийн 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 12 дугаар тогтоолын Үндэслэх хэсгийн 10 дугаар талд “... Их хурал, намын даргын сонгуулийг зохион байгуулсан сонгуулийн байгууллагын шийдвэрүүд хоорондоо зөрчилтэй, намын төлөөллийн төв байгууллага болох ҮБХ нь 2 өөр бүрэлдэхүүнээр тус тусдаа асуудлыг шийдвэрлэсэн нь намын Үндсэн дүрэмд нийцэхгүй байна”, “... намын даргыг сонгох ... дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой маргааныг намын эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх нь хуульд нийцнэ” гэж, мөн шүүхийн 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 15 дугаар тогтоолын Үндэслэх хэсгийн 2 дугаар талд “... хуулийн этгээд нь улсын бүртгэлийн байгууллага, албан тушаалтны хууль ёсны шийдвэр шаардлагыг биелүүлэх үүрэгтэй” гэж заасны дагуу Ардчилсан намын Ээлжит бус “Онц Их Хурал”-аар дараах асуудлыг эцэслэн шийдвэрлэлээ.

Тодруулбал, намын хяналтын байгууллага болох Үндсэн дүрмийн хороо, сонгуулийн байгууллага болох Дотоод сонгуулийн хороо, төлөөллийн төв

байгууллага болох Үндэсний бодлогын хорооны бүрэн эрх, эрх зүйн чадамжийн талаар мөн намын Удирдлагатай холбоотой дотоод асуудлыг хэлэлцэж, энэ тухай гаргасан шийдвэрүүдээрээ Улсын дээд шүүхийн тогтоолуудад заасан зөрчлийг арилгалаа.

Хурлаар хэлэлцсэн асуудлыг дэлгэрүүлэн авч үзье.

Нэг. Ардчилсан намын Ээлжит бус “Онц Их Хурал”-ыг товлох, хэлэлцэх асуудлыг батлах, төлөөлөгчийг сонгох зэрэг хурлын үйл явц бүхэлдээ Үндсэн дүрэм, бусад журамд нийцсэн тухай авч үзье.

1.1. Үндсэн дүрмийн 5.13.12-д “ҮБХ нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд: 5.13.12.23. Ээлжит ба ээлжит бус Их хурлын тов, хэлэлцэх асуудлыг тогтоох” гэсний дагуу ҮБХ-ны Ээлжит бус хурлын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 22/07 дугаар тогтоолоор Ардчилсан намын Ээлжит бус “Онц Их Хурал”-ын товыг 2021 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр товлож, Ардчилсан намын Ээлжит бус “Онц Их Хурал”-ын хэлэлцэх асуудлыг ҮБХ-ны Ээлжит бус хурлын 11 дүгээр сарын 04-ний өдрийн 22/11 дүгээр тогтоолоор тус тус тогтоожээ.

Үүнтэй уялдаад Ээлжит бус “Онц Их Хурал” хуралдах урдач нөхцлийн талаар буюу ҮБХ-ны Ээлжит бус хурлын үйл явц Үндсэн дүрэм, бусад журамд нийцсэн тухай авч үзье.

Намын улсын бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбоотой асуудлыг намын Их хурлаар эцэслэн шийдвэрлүүлэхээр ҮБХ-ны 1/3-ээс доошгүй буюу 247 гишүүний шаардаж гарын үсэг зурсны дагуу Улс төрийн Зөвлөл Үндсэн дүрмийн 5.13.13.1 дэх заалтад үндэслэн тус хорооны хурлыг 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр байхаар товлож, энэ тухай тогтоол гаргасан.

Дээрх товын дагуу хуралдсан ҮБХ ээлжит бус 11 дүгээр сарын 04-ний өдөр үргэлжлэн хуралдахдаа Үндсэн дүрмийн 5.13.12.24 дэх заалтаар “Намын Их хурлын дарга, тэргүүлэгчдийг томилох” гэсний дагуу Ардчилсан намын Ээлжит бус “Онц Их Хурал”-ын дарга, тэргүүлэгчдийг 22/13 дугаар тогтоолоор; мөн Ардчилсан намын “Намын байгууллагуудын хурлын үйл ажиллагаа, зохион байгуулалтын дэгийн тухай журам”-аар Их хурлын тооллого, редакцийн комиссыг 22/14, 22/15 дугаар тогтоолоор тус тус томилсон байдаг.

1.2. Үндсэн дүрмийн 5.12.3-д “Их хурлын төлөөлөгчид нь сонгогдох, томилогдох зарчмаар бүрдэх бөгөөд ... нийслэлд дүүргийн хороо тус бүрээс 2, аймагт 10000-аас дээш хүн амтай сумын баг бүрээс 1, бусад сумдаас тус бүр 1 төлөөлөгч сонгох ба Намын Дарга, ҮБХ, ҮДХ, ДоСХ-ны гишүүд, намын дэргэдэх байгууллагын гүйцэтгэх удирдлага томилогдоно” гэсний дагуу Ээлжит бус “Онц Их Хурал”-ын төлөөлөгчөөр сонгогдсон 886, томилогдсон 432 буюу Улсын Их Хурлын 13, Үндэсний бодлогын хорооны 385, Дотоод сонгуулийн хорооны 15, Үндсэн дүрмийн хорооны 15, Ардчилсан намын дэргэдэх байгууллагын 4 нийт 1318 төлөөлөгчийг ДоСХ-ны 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 18 дугаар тогтоолоор батлан Их хуралд өргөн мэдүүлжээ.

Учир нь Үндсэн дүрмийн 5.22.5.1 дэх заалтаар ДоСХ нь Намын Их Хурлын төлөөлөгч сонгох сонгуулийг Үндсэн дүрэм, бусад журмын дагуу зохион байгуулж, дүнг нэгтгэн мэдээлэх, эрх бүхий байгууллагад өргөн мэдүүлэх үндсэн чиг үүрэгтэй байгууллага бөгөөд энэ чиг үүргийнхээ хүрээнд аймаг, нийслэл, дүүргийн Дотоод сонгуулийн нутаг дэвсгэрийн хороод болон хэрэг эрхлэх газрын дарга нарт Их хурлын төлөөлөгчийг сонгох сонгуулийг зохион байгуулж, нэрсийг ирүүлэх

чиглэлийг өгсөн.

Дээрх чиглэлийн дагуу 21 аймаг, 9 дүүрэг, 330 сум, 171 хорооноос төлөөлөгчөө сонгосон тогтоол, төлөөлөгчийн анкет, тэмдэглэл болон холбогдох материалыг ирүүлжээ.

Хоёр. АН-ын Ээлжит бус “Онц Их Хурал”-аар хэлэлцсэн асуудлыг дарааллын дагуу авч үзье.

#### 2.1. АН-ын Үндсэн дүрмийн хороо эрх зүйн чадамжтай тухай:

Улс төрийн намын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Намын дотоод зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог намын дүрмээр зохицуулна” гэж, Ардчилсан намын Үндсэн дүрмийн 5.21.1-д “Үндсэн дүрэм, бусад журмыг сахиулах, хэрэгжилт болон намын үйл ажиллагаа, гишүүний ёс зүй, сахилгын асуудалд хяналт тавих, чиг үүрэг бүхий төв байгууллага нь Үндсэн дүрмийн хороо” байна гээд мөн дүрмийн 5.12.4 дэх хэсэгт Үндсэн Дүрмийн Хорооны гишүүдийг намын эрх барих дээд байгууллага буюу Их хурал намын даргын санал болгосноор томилж, чөлөөлөхөөр заасан.

Дээрх үндэслэлээр Үндсэн дүрмийн хороо нь анх 2017 оны намын VII Их хурлын 06 тоот тогтоолоор С.Билэгсайхан, Д.Бямбаа, Б.Болдбаатар, Л.Эрхэмбаяр, Т.Баяраа, Б.Мэдрээ, С.Ламбаа, М.Лут-Очир, Л.Байгал, Д.Золжаргал, Д.Ганбаяр, Д.Даваа-Очир, Б.Мягмардаш, Л.Доржсүрэн, Д.Мэндбаяр нарын 15 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан юм.

Уг бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийг тодруулбал, намын VIII Их хурлын 2017 ны 05 дугаар сарын 06-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор С.Билэгсайхан, Л.Байгаль, М.Лут-Очир, Б.Бямбаа нарын оронд Р.Хатанбаатар, А.Зангад, С.Чинзориг, А.Долгормаа нарыг, намын IX Их хурлын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 07 тоот тогтоолоор Д.Даваа-Очир, Б.Мэдрээ нарын оронд Н.Ариунболд, А.Амгалан нарыг, мөн Үндэсний бодлогын хорооны 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 14/09 дүгээр тогтоолоор Ж.Төмөрбаатарыг түр томилсон ба төрийн тусгай албанд шилжсэнтэй нь холбогдуулан Б.Болдбаатарыг намын гишүүнээс түдгэлзүүлсэн тул хорооны бүрэлдэхүүнээс гарсан байдаг. /Боть-2, Үндсэн дүрмийн хорооны үүсгэн байгуулагдсан баримт бичиг 77 хуудас/

Хууль ёсны ардчилсан намын үндсэн дүрмийн хорооны бүрэлдэхүүн

Хүснэгт-1

1.	Б.Мягмардаш	Дарга
2.	А.Амгалан	Гишүүн
3.	Н.Ариунболд	
4.	Т.Баяраа	
5.	Д.Ганбаяр	
6.	Л.Доржсүрэн	
7.	А.Долгормаа	
8.	Д.Мэндбаяр	
9.	С.Ламбаа	
10	Р.Хатанбаатар	

11	Ж.Төмөрбаатар	
12	С.Чинзориг	
13	А.Зангад	
14	Л.Эрхэмбаяр	

Дээрх бүрэн эрх бүхий гишүүдийн гаргасан шийдвэрээс бусад Үндсэн дүрмийн хорооны нэр барьж гаргасан аливаа шийдвэр, үйл ажиллагааг дүрмийн бус гэж үзэн, хүчингүй тухай Та бүхэнд дахин толилуулж байна.

Тодруулбал, Үндсэн дүрмийн хорооны 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 15 дугаар дүгнэлтээр “Х.Алтанхуяг нарын хууль бус бүрэлдэхүүнтэй дотоод сонгуулийн хорооны 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 14 дүгээр тогтоол, 2021 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 15 дугаар тогтоол, 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 21 дүгээр тогтоол, 2021 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 22, 23 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүйд” тооцсоныг Улсын дээд шүүх хүлээн авсан хэдий ч энэхүү дүгнэлт дангаараа “Улсын дээд шүүхийн 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 12 болон мөн шүүхийн 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 15 дугаар тогтоолуудад заасан нөхцөл байдал арилсныг хангалттай нотлохгүй байна” гэж тус шүүхийн 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 4/2555 тоот албан бичигт дурджээ.

Гурав. АН-ын Дотоод сонгуулийн хороо эрх зүйн чадамжтай тухай:

3.1. Үндсэн дүрмийн 3 дугаар бүлгийн 3.10.1.4, 5 дугаар бүлгийн 5.22.5.1 дэх заалт, Ардчилсан намын Дотоод сонгуулийн хорооны журмын 4.5 дахь заалтын дагуу намын дотоод сонгуулийг Үндсэн дүрэм, бусад журмын дагуу зохион байгуулж, дүнг нэгтгэн мэдээлэх, заасан хугацаанд багтаан эрх бүхий байгууллагад өргөн мэдүүлэх чиг үүрэгтэй намын үндсэн бүтэц болох ДоСХ-г намын Их хурлаас 15 гишүүнтэй, 4 жилийн хугацаагаар байгуулдаг бөгөөд дараагийн Их хурлаар шинэ бүрэлдэхүүнийг томилох хүртэл эрх, үүргээ хэрэгжүүлдэг.

Дотоод сонгуулийн хорооны анхны бүрэлдэхүүнийг 2017 онд АН-ын VII Их хурлын 07 тоот тогтоолоор томилж, уг бүрэлдэхүүнд АН-ын VIII Их хурлын 12, АН-ын IX Их хурлын 07 тоот тогтоолоор тус тус өөрчлөлт орсон.

Үүний дараа Улс төрийн намын тухай хуулийн 13.4-т “Намын Их Хурлаар батлагдсан ..., сонгогдсон бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг намын төлөөллийн төв байгууллага шийдвэрлэж болно” гэх, Үндсэн дүрмийн 5.13.12.14. ДоСХ-ны 1/3 хүртэлх бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж намын даргын санал болгосноор намын Их хурал хуралдах хүртэл гишүүнийг түр томилох эрхтэй” гэсний дагуу АН-ын төлөөллийн төв байгууллага болох Үндэсний бодлогын хороо нь 2019 оны 11 дүгээр тогтоолоор Н.Цэнгэлийн оронд Х.Түмэнбаярыг томилсон, 2020 оны 14/07 дугаар тогтоолоор Ж.Төмөрбаатар, Э.Батсуурь нарыг чөлөөлсөн, мөн оны 14/08 дугаар тогтоолоор Л.Ганхөлөгийг томилсон зэрэг өөрчлөлтийг бүрэлдэхүүнд оруулсан байдаг.

Хууль, дүрмийн дээрх заалтаас намын төлөөллийн төв байгууллага нь намын зарим бүтцэд өөрчлөлт оруулах боломжтой ч 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрөөс хойш өнөөдрийг хүртэл ДоСХ-ны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах эсэх асуудлаар АН-ын Үндэсний бодлогын хороо ямар нэг шийдвэр гаргаагүй болно. Мөн дээр дурдсанчлан Үндсэн дүрмийн 5.13.12.14-д ДоСХ-ны 1/3 хүртэлх бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж намын даргын санал болгосноор намын Их хурал хуралдах хүртэл

гишүүнийг түр томилох эрхтэй” гэх заалтыг Үндэсний бодлогын хороо хэрэгжүүлэхдээ намын даргын саналыг заавал харгалздаг. /Боть-3, Дотоод сонгуулийн хорооны үүсгэн байгуулагдсан баримт бичиг 1-48 хүртэлх хуудас/

Хууль ёсны ардчилсан намын дотоод сонгуулийн хорооны бүрэлдэхүүн

Хүснэгт-2

1.	И.Мөнхжаргал	Дарга
2.	Т.Батчулуун	Дэд дарга
3.	Х.Оюунчулуун	Нарийн бичгийн дарга
4.	О.Алтангэрэл	Гишүүн
5.	Б.Ариунболд	
6.	Л.Ганхөлөг	
7.	С.Майнбаяр	
8.	Т.Мөнхбаяр	
9.	Л.Нармандах	
10	Х.Түмэнбаяр	
11	Д.Оросоо	
12	Э.Цэндсүрэн,	
13	Ч.Чулуунчимэг	

Дээрх бүрэн эрх бүхий гишүүдийн гаргасан шийдвэрээс бусад Дотоод сонгуулийн хорооны нэр барьж гаргасан аливаа шийдвэр, үйл ажиллагааг дүрмийн бус гэж үзэн, хүчингүй тухай Та бүхэнд дахин толилуулж байна.

Дөрөв. АН-ын Үндэсний бодлогын хорооны эрх зүйн чадамжтай тухай:

4.1. Үндсэн дүрмийн 5.13.1-д “Намын төлөөллийн төв байгууллага нь Үндэсний Бодлогын Хороо мөн” гэж, 5.13.2-т “ҮБХ нь Үндсэн дүрэмд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын сонгуулийн тойргийн мандатын тоог 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү тооны гишүүдтэй байна. Үүнээс 76-аас доошгүй нь эмэгтэй, 76-аас доошгүй нь 39-өөс дээшгүй насны гишүүдэд ногдоно” гэж заасны дагуу байгуулагдсан Үндэсний бодлогын хорооны бүрэлдэхүүнийг Коронавируст /КОВИД-19/ цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан эрх бүхий байгууллагаас дараагийн бүрэлдэхүүн томилогдох хүртэл бүрэн эрхээ хэвээр хадгалж, чиг үүргээ хэрэгжүүлж байхаар шийдвэрлэлээ. /Боть-4, Үндэсний бодлогын хороо үүсэн байгуулагдсан баримт, бичиг мөн одоогийн байгаа бүрэлдэхүүний нэрс 134 хуудас/

Дээрх бүрэн эрх бүхий гишүүдийн гаргасан шийдвэрээс бусад Үндэсний бодлогын хорооны нэр барьж гаргасан аливаа шийдвэр, үйл ажиллагааг дүрмийн бус гэж үзэн, хүчингүй тухай Та бүхэнд дахин толилуулж байна.

Тав. АН-ын баримт бичигт оруулсан өөрчлөлт тодруулбал, АН-ын даргын сонгууль холбогдох хууль, Үндсэн дүрэм бусад журамд нийцсэн тухай:

5.1 Улс төрийн намын тухай хуулийн 4.1-т “Нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн” гэж, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтад “... Нам, ..., нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг

дээдлэн биелүүлнэ” гэж, мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх заалтад “Нам Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана”, мөн зүйлийн 3 дахь заалтад “Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, ... байна” гэж тус тус хуульчилсан.

Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо, Чингисийн өргөн чөлөө “Шинэ дэвшилтэт” холбооны байранд үйл ажиллагаа явуулж буй Улсын бүртгэлийн гэрчилгээний 8082001002 дугаартай Ардчилсан нам нь гишүүдийнхээ сонгох сонгогдох, эвлэлдэн нэгдэх, төрийн үйл хэрэгт шууд оролцох, сонгож байгуулсан төлөөлөгчдийнхөө байгууллагаар уламжлан эл эрхээ эдлэх боломжийг цаг ямагт илэрхийлж, тэдний бодит оролцоонд тулгуурлан эрхийг нь хангахыг чухалчилдаг билээ.

Ардчилсан намын сонгуулийн байгууллага болох Дотоод сонгуулийн хороо нь үйл ажиллагаандаа эрх тэгш хандах, шударга ёсыг баримтлах, ил тод байдлыг хангах, хууль болон Үндсэн дүрэм, бусад журам дээдлэх зарчмыг удирдлага болгож ирсэн.

Үндсэн дүрэм болоод Дотоод сонгуулийн хорооны журамд зааснаар ДоСХ нь намын даргын сонгуулийг дараах үйл явцын дагуу зохион байгуулна. Үүнд:

Дотоод сонгуулийн нутаг дэвсгэрийн хороодоор дамжуулан сонгуулийг зохион байгуулахдаа санал авах байрны байршлыг 21 аймаг, 9 дүүрэг, сум, хороодоор баталж, хаяг байршлыг гишүүдэд урьдчилан мэдэгдэж, саналаа биечлэн өгөх боломжоор хангаж, санал авах ажиллагааг төв намын Хэрэг эрхлэх газраас гаргаж ирүүлсэн намын гишүүдийн нэгдсэн бүртгэл дээр үндэслэн зохион байгуулна. Гишүүд саналаа биечлэн өгөх нь нэг хүн нэг саналын эрх эдлэх, сонгох, сонгогдох эрхээ бодитой эдлэх, шударга, ил тод санал хураалт явагдах нөхцөлийг бүрдүүлдэг. Тиймээс ч АН-ын Үндсэн дүрэм болон Дотоод сонгуулийн хорооны журамд “Цахим сонгууль” явуулах эрх зүйн зохицуулалт байхгүй. Тиймээс 2021 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр хуралдсан АН-ын Ээлжит бус “Онц Их Хурал”-аас Х.Алтанхуяг нарын хууль бус бүрэлдэхүүнтэй Дотоод сонгуулийн хорооны 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 14 дүгээр тогтоол, 2021 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 15 дугаар тогтоол, 2021 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 19 дүгээр тогтоол, 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 19 дүгээр тогтоол, 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 20 дугаар тогтоол, 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 21 дүгээр тогтоол, 2021 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 22 дугаар тогтоол, 2021 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 23 дугаар тогтоолууд мөн 2021 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн Үндэсний бодлогын хорооны тогтоолууд, 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн Ээлжит бус цахим XI Их хурлын тогтоолуудыг Үндсэн дүрэм холбогдох журамд нийцээгүйг тогтоож, бүхэлд нь хүчингүй болгож шийдвэрлэлээ.

“Дотоод сонгуулийн нутаг дэвсгэрийн хороо”-г 5-7 хүний бүрэлдэхүүнтэйгээр намын гишүүдээс сонгож 4 жилийн хугацаагаар байгуулдаг бөгөөд дараагийн бүрэлдэхүүнийг эрх бүхий байгууллагаас томилох хүртэл бүрэн эрхээ хэрэгжүүлдэг. Тус хороо нь Дотоод сонгуулийн хорооноос өгсөн чиглэлийн дагуу тухайн нутаг дэвсгэртээ сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулж, дүн мэдээг нэгтгэн журамд заасан хугацаанд Дотоод сонгуулийн хороонд ирүүлэх үндсэн чиг үүрэгтэй. /Боть-3, Дотоод сонгуулийн нутаг дэвсгэрийн хороодын үүсгэн байгуулагдсан баримт бичиг 49-175 хүртэлх хуудас/

Улс төрийн намын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Намын дотоод

зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог намын дүрмээр зохицуулна” гэж, АН-ын Үндсэн дүрмийн 5.12.4-д “Их хурал нь дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд: 5.12.4.8-д “Намын Даргыг ёсчлон батламжлах,” хэмээн тус тус заасны дагуу ДоСХ-ны 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор товлогдож, 2021 оны 03 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд санал хураалт явагдсан Ардчилсан намын даргын сонгуулийг Үндсэн дүрэм, бусад журамд нийцсэн, хүчинтэй гэж Ардчилсан намын Ээлжит бус “Онц Их Хурал”-аас шийдвэрлэлээ.

Тодруулбал, АН-ын ДоСХ-ны 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 15 дугаар тогтоолоор Намын даргын сонгуульд 43259,8 оноо авч Ардчилсан намын даргаар сонгогдсон Одонгийн Цогтгэрэлийг Ардчилсан намын даргаар Ёсчлон батламжилж, Улсын дээд шүүхийн 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 12 дугаар тогтоол, мөн шүүхийн 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 15 дугаар тогтоолд заасан зөрчлийг арилгалаа.

Иймд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8 дахь заалт, Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын дагуу Ардчилсан намын баримт бичигт оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэх хүсэлтээ хүргүүлж байгааг хүлээн авч, шийдвэрлэж өгнө үү” гэжээ.

Уг хүсэлтэд, Бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулах тухай өргөдөл /Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын хавсралт №2/, Ардчилсан намын улсын бүртгэлийн гэрчилгээ /эх хувь/, улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, Улсын дээд шүүхийн 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 4/2555 тоот албан бичгийн хуулбар, О.Цогтгэрэлийн 2021 оны 11 дүгээр сарын 10-ны бдрийн 01/35 дугаартай “Буянаа овогтой Ган-Очир нь Ардчилсан намын Хэрэг эрхлэх газрын даргаар ажилладаг нь үнэн болно” гэх тодорхойлолт болон 38 хавтас, 4100 хуудас материалыг хавсарган ирүүлжээ.

Түүнчлэн, Б.Ган-Очироос 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 02/209 дүгээр “Мэдээлэл хүргүүлэх тухай” албан бичгээр “... АН-ын баримт бичигт оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбогдуулан дараах мэдээллийг хүргэж байна: ... АН-ын Ээлжит бус хурал хуралдах урдач нөхцөл Үндсэн дүрэмд нийцсэн эсэх, ... ҮДХ эрх зүйн чадамжтай тухай, ... ДоСХ эрх зүйн чадамжтай тухай, ... ҮБХ эрх зүйн чадамжтай тухай, ... АН-ын даргын сонгууль холбогдох хууль, Үндсэн дүрэм бусад журамд нийцсэн тухай ...” гэх 7 хуудас, 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн “Тайлбар, хүсэлт гаргах тухай” 02/208 дугаар албан бичгээр “... Улсын дээд шүүхийн 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 12 дугаар тогтоол, 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 15 дугаар тогтоолд заасан зөрчлийг арилгасан...”, “Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасны дагуу ... Үндсэн дүрэм, журмын хүрээнд намын нийт гишүүдээсээ сонгогдож, намын Их хурлаар ёсчлон батламжлагдсан О.Цогтгэрэлээс тайлбар, санал авч, сонсох ажиллагаа зохион байгуулахыг хүсье” гэх, 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 03/215 дугаар алба бичгээр “...нэмэлт тайлбарыг гаргаж байна: ... Улсын дээд шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 04 дүгээр тогтоол, 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 09 дүгээр тогтоол, 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 12 дугаар тогтоол, 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 15 дугаар тогтоол, 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 30 дугаар тогтоолуудад тус тус заасан зөрчлийг хэрхэн арилгасан талаар хүснэгтээр тоймлон харуулав” гэх, 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 229 дүгээр албан бичгээр “... үүрэгт ажлаасаа огцорсон С.Эрдэнэ болон АН-д ямар нэг албан тушаал эрхэлдэггүй О.Баасанхүү нарын зүгээс намын баримт бичигт оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэх тухай материалыг хүргүүлж, үүгээрээ нам дотоод асуудлаа шийдээгүй хэвээр байгаа мэт

илт зохиомол байдлыг зориудаар бий болгож байна. ... намын дотоодод ямар нэг зөрчил байхгүй гэдгийг үүгээр уламжилж байна” гэх 2 хуудас нэмэлт тайлбарыг тус тус ирүүлсэн байна.

Ардчилсан намын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Ган-Очирын ирүүлсэн намын баримт бичигт оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэх хүсэлттэй холбогдуулж, Ардчилсан намын дарга гэх С.Эрдэнээс “... УИХ-ын гишүүн О.Цогтгэрэл нараас АН-ын нэрийг барин 2021.11.05-ны өдөр АН-ын “Онц их хурал”-ыг ... хууль бусаар зохион байгуулсан, Хурлыг зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагаа нь Улс төрийн намын тухай хууль, АН-ын Үндсэн дүрмийг зөрчсөн, ... “Онц их хурал”-аас гаргасан шийдвэрүүдийг УДШ-д бүртгүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа нь хууль, дүрэм зөрчсөн, хүчин төгөлдөр бус, хүлээн зөвшөөрөх боломжгүй...” гэх мэдэгдлийг, 11 хуудас бичгийн баримтын хамт 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 249 тоот албан бичгээр, түүнчлэн, “... 2021 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр АН-ын ҮБХ-ны шинэчилсэн бүртгэлд байдаггүй хэсэг хүмүүс намын онц Их хурал гэгчийг хуралдуулж О.Цогтгэрэлийг АН-ын даргаар бүртгүүлэх гэсэн хууль бус шийдвэрийг ... УДШ-д хүргүүлсэн байна. ... О.Цогтгэрэлийг бүртгүүлэх өргөдлийг УДШ-д хүргүүлэхдээ Улсын бүртгэлийн ерөнхий газрын хяналтын улсын байцаагчийн 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 6030 дугаартай шийдвэрээр хүчингүй болсон 11117237845 тоот тамгыг ашигласан байгаа нь тамга, тэмдэг хэрэглэх журмыг зөрчсөн ... Хүчингүй тамга ашигласан нь О.Цогтгэрэлийг намын даргаар бүртгүүлэх өргөдлийг буцаах үндэслэлтэй. АН нь өнөөдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн шийдвэрээр олгогдсон 9020120477 тоот тамгыг хэрэглэж байгаа болно. Иймд ... О.Цогтгэрэлийг АН-ын даргаар бүртгүүлэхээр хүргүүлсэн өргөдөл болон АН-ыг төлөөлөх эрхгүй этгээдүүд /О.Цогтгэрэл, М.Тулгат/-ийн гарын үсэг зурж, хүчингүй тамга дарагдсан АН-ын даргын бүртгэлтэй холбоотой холбогдох хууль, журмыг зөрчин хүргүүлсэн баримтуудыг буцаан ирүүлнэ үү” гэх хүсэлтийг 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 262 дугаар албан бичгээр тус тус ирүүлсэн байна.

#### ҮНДЭСЛЭХ нь:

Ардчилсан намын Үндсэн дүрмийн 5.12.2-т “... Их хурлын ээлжит, ээлжит бус хуралдааныг ҮБХ-ны нийт гишүүдийн ердийн олонхи /50-аас дээш хувь/-ийн саналаар эсвэл Намын Дарга зарлан хуралдуулна”, 5.13.2-т “ҮБХ нь Үндсэн дүрэмд өөрөөр заагаагүй бол УИХ-ын сонгуулийн тойргийн мандатын тоог 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү тооны гишүүдтэй байна...” гэж тус тус заасан, Улсын дээд шүүхэд хадгалагдаж байгаа Ардчилсан намын улсын бүртгэлийн баримтууд болон хүсэлтэд хавсаргаж ирүүлсэн бичгийн баримтуудыг тулгаж үзэхэд, Үндэсний бодлогын хорооны гишүүд (Ардчилсан намын VIII Их хурлын 2017 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан 389 гишүүн)-ийн 229 буюу 58.9 хувь<sup>1</sup> нь Ардчилсан намын Их хурлын хуралдааныг зарлан хуралдуулахаар санал гаргасан нь тогтоогдлоо, энэ нь Ардчилсан намын Үндсэн дүрмийн 5.12.2-т заасантай нийцжээ.

Ардчилсан намын ээлжит бус Их хурлын 2021 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 13 дугаар тогтоолын 4 дэх заалтаар “Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын дагуу АН-ын баримт бичигт орсон өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбоотой

<sup>1</sup> дэмжсэн хуудсыг давхардуулж оруулсан 2, 2020 онд нөхөн сонгогдсон гэх 2, ҮБХ-ны гишүүн бус хуралдааныг дэмжсэн АН-ын гишүүн гэх 7, ҮБХ-ны гишүүдийн нэрсээс шүүж үзэхэд нэр байхгүй 7, нийт 18 саналын хуудас зөрчилтэй



асуудлаар Улсын дээд шүүхэд Ардчилсан намыг төлөөлөн захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд оролцох, харилцах итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр /Б.Ган-Очир/-ыг /томилсон/" байх тул Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдлийг өргөдөл гаргах эрх бүхий этгээд гаргах"-аар, 22 дугаар зүйлийн 22.1.5-д "шаардлагатай тохиолдолд итгэмжлэл"-ийг хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд бүрдүүлэхээр заасантай мөн нийцсэн гэж үзэхээр байна.

Түүнчлэн, Ардчилсан намын Үндсэн дүрмийн 5.13.12-т "ҮБХ нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд: 5.13.12.23. Ээлжит ба ээлжит бус Их хурлын тов, хэлэлцэх асуудлыг тогтоох" гэсний дагуу Ардчилсан намын Үндэсний бодлогын хорооны 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 22/07 дугаар тогтоолоор Ардчилсан намын Ээлжит бус Их хурлыг 2021 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулахаар, мөн хорооны 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 22/11 дүгээр тогтоолоор уг Их хурлаар "1. АН-ын улсын бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбоотой маргаантай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх; 2. Үндсэн дүрмийн өөрчлөлт боловсруулах ажлын хэсэг байгуулах" гэсэн хоёр асуудлыг хэлэлцэхээр шийдвэрлэсэн нь Ардчилсан намын Үндсэн дүрмийн 5.12.4.11-т "/Их хурал нь/ намын бүхий л асуудлаар хэлэлцэж, шийдвэр гаргах" гэсний хүрээнд байна гэж үзлээ.

Харин, Ардчилсан намын Үндсэн дүрмээр намын даргыг Их хурал шууд сонгохоор заагаагүй, Үндсэн дүрмийн 5.12.4.8-д "/Их хурал нь/ намын даргыг ёсчлон батламжлах" гэж заасан нь Үндсэн дүрэм, холбогдох бусад намын дотоод сонгуулийн дүрэм, журмын дагуу сонгуулиар сонгогдсон намын даргыг Их хурлаараа батламжлах агуулгатай, энэ тохиолдолд, 2021 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулагдсан Ардчилсан намын Ээлжит бус Их хурлын хэлэлцэх асуудалд "намын даргыг ёсчлон батламжлах" асуудал тусгагдаагүй, түүнчлэн Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 12 дугаар тогтоолоор Дотоод сонгуулийн хорооны 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор товлогдож, 2021 оны 03 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд санал хураалт явагдсан Ардчилсан намын даргын сонгууль нь Үндсэн дүрэмд нийцэхгүй гэж дүгнэгдсэн буюу өмнө нь Улсын дээд шүүхээс "Үндсэн дүрмийн дагуу сонгогдоогүй" гэж үзсэн О.Цогтгэрэлийг тус Их хурлаас намын даргаар ёсчлон батламжилсныг "Ардчилсан намын Үндсэн дүрмийн хүрээнд" гэж дүгнэх боломжгүй байна.

Тодруулбал, Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 12 дугаар тогтоолоор:

"... АН-ын ХЭГ-ын дарга П.Нүрзэд 2021.04.08-ны өдөр ирүүлсэн хүсэлтдээ "...О.Цогтгэрэлийг намын даргаар сонгож батламжилсан тул ...намын хувийн хэрэг дэх намын удирдлагатай холбоотой өмнө нь бүртгэгдсэн мэдээлэлд өөрчлөлт оруулж, бүртгэж өгнө үү" гэх хүсэлт гаргаж, хүсэлтдээ өргөдөл, АН-ын ээлжит бус Их хурлын тов, хэлэлцэх асуудал, хуралд бэлтгэх ажлын хэсгийг батлах тухай ҮБХ-ны 2021.03.11-ний өдрийн 20/10 дугаар тогтоол, хавсралт, АН-ын дотоод сонгуулийг товлон зарлах тухай Дотоод сонгуулийн хорооны 2021.02.24-ний өдрийн 03 тогтоол, уг тогтоолд өөрчлөлт оруулах тухай 04 тогтоол, Дотоод сонгуулийн хорооны нэр дэвшигчээр бүртгэх тухай 07, намын даргын сонгуулийн санал хураалтын дүнг баталгаажуулах тухай 14, сонгуулийн дүнг өргөн мэдүүлэх тухай 15 дугаар тогтоол, ҮБХ-ны 2021.04.02-ны өдрийн 21/09, 21/08, 21/06, 21/07 дугаар тогтоол, АН-ын ээлжит бус Их хурлын 2021.04.03-ны өдрийн 01, 02, 03, 04, 05, 07 дугаар тогтоол, тооллогын болон редакцийн комиссын тогтоолууд, АН-ын даргыг батламжлах ээлжит бус Их хурлын тэмдэглэл, АН-ын гишүүдийн нэгдсэн бүртгэл, даргын

сонгуульд санал өгсөн гишүүдийн гарын үсэг бүхий нэрсийн хавтгай болон 2021.04.13, 2021.04.23, 2021.04.26-ны өдрийн албан бичгээр нэмэлт тайлбарыг ирүүлсэн. ... И.Мөнхжаргал даргатай ДоСХ-ны 2021.02.24-ний өдрийн 03, 2021.03.02-ны өдрийн тогтоолоор намын даргын сонгуульд нэр дэвшигчийг бүртгэх, сонгуулийн сурталчилгаа явуулах, санал хураалтыг зохион байгуулах хугацааг тогтоосон, 2021.03.30-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор санал хураалтын дүнг баталгаажуулж, нийтэд зарлахыг хорооны даргад даалгасан, 2021.03.31-ний өдрийн 15 дугаар тогтоолоор намын даргад О.Цогтгэрэлийг Их хуралд өргөн мэдүүлэхийг үүрэг болгожээ.

... Х.Алтанхуяг даргатай ДоСХ-ны 2021.03.20-ны өдрийн 15 дугаар тогтоолоор Намын даргын сонгуульд нэр дэвшигчийг бүртгэж, үнэмлэх олгосон, 2021.04.05-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор 2021.04.06-ны өдрийн 10.00 цагаас 22 цагийн хороонд цахим санал хураалтыг товлон зарлаж, Их хуралд сонгогдсон төлөөлөгчдийн нэрсийг хавсралтын дагуу цахим сонгуулийн системд оруулж, санал хураалтыг зохион байгуулахыг үүрэг болгосон, 2021.04.06-ны өдрийн 23 дугаар тогтоолоор Ардчилсан намын даргын цахим сонгуулийн дүнг нэгтгэхэд 2,133.82 оноо буюу хамгийн өндөр оноо авсан М.Тулгатыг АН-ын даргаар сонгогдсонд тооцож, нэр дэвшигч М.Тулгатыг АН-ын ээлжит бус XI Их хуралд өргөн мэдүүлэхийг ДоСХ-ны даргад үүрэг болгожээ.

... АН-ын Үндсэн дүрмийн хорооны /цаашид ҮДХ-ны гэх/ дэд дарга Д.Ганбаярын 2021.04.05-ны өдрийн албан бичигт “..хэсэг бүлэг гишүүд 2021.04.03-ны өдөр Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Дүнжингарав худалдааны төвийн гадаа талбайд цагдаагийн мэдээллээр 500 гаруй иргэдийг цуглуулан Намын даргыг сонгох Их хурал гэгчийг зохион байгуулж Улсын дээд шүүхэд бүртгүүлэх ажиллагааг зохион байгууллаа. Энэ нь Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Улсын онцгой комиссын тогтоол шийдвэр, Ардчилсан намын дүрэм зэргийг зөрчсөн байх тул тухайн Их хурлаар сонгогдсон гэх Ардчилсан намын гишүүн О.Цогтгэрэлийг Улсын дээд шүүхэд бүртгэх хуралдааныг хуралдуулахгүй, бичиг баримтын бүрдүүлбэрийг хүлээн авахгүй буцаан ирүүлнэ үү” гэж,

... АН-ын ЕНБД Ч.Өнөрбаярын 2021.04.12, 2021.04.14, 2021.04.15, 2021.04.20, 2021.04.21-ний өдрийн албан бичигт “... АН-ыг төлөөлөх эрхгүй этгээдүүд намын даргыг батламжлуулахаар холбогдох материалыг Улсын дээд шүүхэд хүргүүлсэн байна. Энэ нь Улс төрийн намын тухай хуулийг зөрчсөн тул тухайн холбогдох материалыг буцаан авах хүсэлтийг гаргаж байна, ... /УДШ-ийн/ тогтоолуудаар Ц.Тувааныг Ардчилсан намыг төлөөлөх эрхгүй этгээд гэж дүгнэсэн ба уг эрхгүй этгээдийн томилсон П.Нүрзэд гэгч нь мөн адил Ардчилсан намыг төлөөлөх эрхгүй болно. ... П.Нүрзэдийн хүсэлт гаргахдаа ашигласан Ардчилсан намын 1117237845 хяналтын дугаартай тамгыг Улсын бүртгэлийн газрын хяналтын улсын байцаагчийн 2020.12.24-ний өдрийн 6030 дугаар дүгнэлтээр хүчингүй болгосон, Улсын бүртгэлийн ерөнхий газраас тус намд 9020120477 тоот тамганы хяналтын дугаар олгогдсон одоо ашиглагдаж байна...”, ...Дүнжингарав худалдааны төвд Их хурал гэх үйл ажиллагаа явуулсан Ц.Туваан, П.Нүрзэд нарыг Зөрчлийн тухай хуулиар хэрэг нээн шалгаж байна”, “...өмнө гаргасан албан бичгийн хариуг яаралтай шийдэж өгнө үү” гэх хүсэлтүүдийг ирүүлжээ.

... Хүсэлтэд хавсаргасан баримтуудаас үзвэл, Их хурал, намын даргын сонгуулийг зохион байгуулсан сонгуулийн байгууллагын шийдвэрүүд хоорондоо зөрчилтэй, намын төлөөллийн төв байгууллага болох ҮБХ нь 2 өөр бүрэлдэхүүнээр тус тусдаа асуудлыг шийдвэрлэсэн нь намын Үндсэн дүрэмд нийцэхгүй байна.

Өөрөөр хэлбэл, Их хурлыг зарлан хуралдуулсан, намын даргыг сонгох сонгуулийн үйл явц нь намын Үндсэн дүрмээр зохицуулагдах тус намын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой маргаан гэж үзэв. Иймд О.Цогтгэрэл, М.Тулгат нарын хэн алиныг намын даргаар бүртгэх боломжгүй гэж нийт шүүгчийн хуралдаанаас дүгнэлээ” гэж;

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 15 дугаар тогтоолоор “/дээрх/ зөрчил арилаагүй /гэж үзэж/ ... , Ардчилсан намын даргаар М.Тулгатыг, О.Цогтгэрэлийг бүртгүүлэх хүсэлтүүдийг нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэхээс татгалзав” гэж;

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн ... тогтоолоор “... Ардчилсан нам нь Улсын дээд шүүхийн 2021 оны 04, 09 дүгээр тогтоол, нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 12 дугаар тогтоолын үндэслэлд заасан зөрчлөө арилгаж, Улс төрийн намын тухай хууль болон Үндсэн дүрэмдээ нийцүүлэн шийдвэр гаргах замаар намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодруулж, ... /энэ/ талаарх баримтаа бүрэн бүрдүүлсний дараа холбогдох хүсэлтээ Улсын дээд шүүхэд дахин гаргах” талаар дурдаж, тус тус шийдвэрлэсэн, уг тогтоолууд хүчин төгөлдөр байна.

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны дээрх тогтоолуудаар 2021 оны 03 дугаар сард явагдсан Ардчилсан намын даргыг сонгох сонгуулийн үйл явц, О.Цогтгэрэл, М.Тулгат нарыг Ардчилсан намын даргаар сонгосон, намын даргын сонгуулийг зохион байгуулсан үйл ажиллагаа болон сонгуулийн байгууллагын холбогдох шийдвэрүүдийг тус тус “Ардчилсан намын Үндсэн дүрэмд нийцэхгүй” гэж нэгэнт дүгнэсэн тул О.Цогтгэрэлийг “Ардчилсан намын Үндсэн дүрмийн дагуу сонгогдсон” гэж үзэх боломжгүй, Ардчилсан нам нь дээрх тогтоолуудад заасан зөрчлөө арилгаж, Үндсэн дүрэм, холбогдох бусад намын дотоод сонгуулийн дүрэм, журмын дагуу намын даргын сонгуулиа дахин зохион байгуулсан болон сонгуулийн үр дүнг баталгаажуулсан талаарх баримтаа Улсын дээд шүүхэд ирүүлээгүй байгаа нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-д “улсын бүртгэлд бүртгүүлэхээр ирүүлсэн баримт бичгийн бүрдэл дутуу”, 18.1.2 “... баримт бичиг энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй” бол улсын бүртгэлд бүртгэхээс татгалзахаар заасан үндэслэлд хамаарч байна.

Иймд, Ардчилсан намын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Ган-Очирын ирүүлсэн хүсэлтийг хангахгүй орхиж, Ардчилсан намын улсын бүртгэлийн мэдээлэлд Одонгийн Цогтгэрэлийг “Ардчилсан намын дарга”-аар бүртгэхээс татгалзах нь зүйтэй гэж нийт шүүгчийн хуралдаанаас дүгнэв.

Ардчилсан нам нь Үндсэн дүрэм, холбогдох бусад дотоод сонгуулийн дүрэм, журмын дагуу намын даргын сонгуулиа дахин зохион байгуулж, зохих ёсоор сонгогдсон этгээдийг Үндсэн дүрэмд заасны дагуу намын даргаар ёсчлон батламжилсан талаарх холбогдох баримтаа бүрдүүлсний үндсэн дээр, “хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээд”-ийг бүртгүүлэхээр дахин хүсэлтээ гаргах эрхийг энэ тогтоол хязгаарлахгүй болохыг дурдах нь зүйтэй.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.2-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Ардчилсан намын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Ган-Очирын “Ардчилсан намын баримт бичигт оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэх”-ээр гаргасан хүсэлтийг

хангахгүй орхиж, О.Цогтгэрэлийг Ардчилсан намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдээр улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсугай.

2. Хүсэлт гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 150,000 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,  
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Д.МӨНХТУЯА